



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/69

Шивээговь сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Говьсүмбэр аймгийн Төрийн аудитын газрын 2019 оны 04/41 тоот “Зөрчил арилгуулах тухай” албан шаардлагыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эзэмшиж авсан газраа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаагүй, мөн газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших гэрээг дүгнэж, захиргааны акт гаргахтай холбогдуулан сонсох ажиллагаа явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Батмөнх

(Засаг даргын орлогч дарга)

Нарийн бичгийн дарга:

Э.Баярмагнай

(Газрын даамал)

Гишүүд:

Б.Баасанбат

(Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

А.Нандинцэцэг

(1 дүгээр багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

А.Энхмаа

(2 дугаар багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2. Газрын тухай хууль тогтоомжийг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших эрхийг хүчингүй болгох, эзэмших эрх хүчингүй болж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагад мэдэгдэх, холбогдох арга хэмжээний тайланг 2020 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн дотор танилцуулахыг /Ажлын хэсэг/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

4212 190